



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 02 сарын 21 өдөр

Дугаар 18

Номгон

Аймгийн Хүн амын асуудлаарх
салбар хороо бүрэлдэхүүн, ажиллах
журмыг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/65 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан “Хүн амын асуудлаарх үндэсний хорооны ажиллах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн хэмжээнд хүн амын асуудлаар баримтлах бодлого, үндэсний болон дэд хөтөлбөр, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэг бүхий “Хүн амын асуудлаарх аймгийн салбар хороо”-ны бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хүн амын асуудлаарх аймгийн салбар хорооны ажиллах журмыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээр батлуулж, аймгийн салбар хорооны чиг үүргийг сумын хэмжээнд хэрэгжүүлэх салбар зөвлөлийг байгуулан ажиллуулах, салбар хорооны жилийн тайланг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Засаг дарга бөгөөд салбар хорооны дарга /Г.Батжаргал/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

D:/2018/Alban bichig/TH togtool-2018

0117159

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2018 оны 02 дугаар сарын 21-ний
өдрийн 18 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



**“ХҮН АМЫН АСУУДЛААРХ АЙМГИЙН
САЛБАР ХОРОО”-НЫ БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга: Аймгийн Засаг дарга

Дэд дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

Гишүүд: Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгч, Нийгмийн хөгжлийн хорооны дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

Аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга

Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга

Аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын дарга

Аймгийн Байгаль орчны газрын дарга

Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга

Аймгийн Статистикийн хэлтсийн дарга

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга

Аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн дэд дарга

Хүний эрхийн үндэсний комиссын аймаг дахь төлөөлөгч

Хүн ам, гэр бүлийн хөгжлийн чиглэлээр ажиллаж буй Төрийн бус байгууллагын төлөөлөл /Тохиролцсоноор/

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах Төрийн бус байгууллагын төлөөлөл /Тохиролцсоноор/

Залуучуудын эрх ашгийг хамгаалах Төрийн бус байгууллагын төлөөлөл /Тохиролцсоноор/


Ахмад настны эрх ашгийг хамгаалах Төрийн бус байгууллагын төлөөлөл
/Тохиролцсоноор/

Олон Улсын байгууллагуудын төлөөлөл /Тохиролцсоноор/

Хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл /Тохиролцсоноор/

_____оо_____

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2018 оны 02 дугаар сарын 21-ний
өдрийн 18 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



АЙМГИЙН ХҮН АМЫН АСУУДЛААРХ САЛБАР ХОРООНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Хүн амын хөгжлийн асуудлаарх салбар хороо /цаашид хороо гэх/-ны үндсэн зорилго нь нутаг дэвсгэрийн хэмжээнд хүн амын бүлгүүдийн хөгжлийг дэмжих бодлого, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, түүнийг бусад салбарын бодлого, төлөвлөлт, төсөл хөтөлбөртэй уялдуулах, иргэний нийгмийн хамтын ажиллагааг сайжруулах, төсөв хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, үйл ажиллагааны үр дүнд үнэлгээ хийх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулахад оршино.

1.2. Хороо нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, бусад холбогдох хууль тогтоомж, олон улсын гэрээ болон энэхүү журмыг удирдлага болгон ажиллана.

1.3. Хорооны үйл ажиллагаанд шаардлагатай хөрөнгийг орон нутгийн төсөвт тусган шийдвэрлүүлэх, ажлаа Үндэсний хороо болон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд тайлагнана.

ХОЁР. ХОРООНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1. Хороо нь төрийн байгууллага, иргэний нийгмийн төлөөлөл бүхий орон тооны бус байгууллага юм.

2.2. Хорооны нарийн бичгийн даргын үүргийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн асуудал хариуцсан мэргэжилтэн гүйцэтгэнэ.

2.3. Хороо нь хүн амын хөгжлийн асуудлаар хийх судалгаа шинжилгээний ажлын хэрэгцээг тодорхойлох, шаардлагатай бол энэ ажлыг гүйцэтгэх, хорооны гишүүд болон холбогдох байгууллагыг мэдээлэл, мэргэжлийн зөвлөмж чиглэлээр үндсэн чиг үүрэг бүхий шинжээч, судлаачдын бүлгийг байгуулан ажиллуулж болно.

ГУРАВ. ХОРООНЫ ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1. Хороо нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ

3.1.1. Хүн амын асуудлаарх бодлого төлөвлөлт боловсруулахад арга зүйн дэмжлэг үзүүлэх

3.1.2. Хүн амын асуудлыг бусад салбарын бодлого, үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах

3.1.3. Хүн амын асуудлаар төрийн болон төрийн бус, холбогдох байгууллага, олон улсын байгууллагатай хамтран ажиллах, хамтын ажиллагааг бэхжүүлэх, үйл ажиллагааны уялдаа холбоог хангах

3.1.4. Хүн амын асуудлаар хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналыг холбогдох газарт уламжлан шийдвэрлүүлэх

3.1.5. Хүн амын асуудалд иргэд, олон нийтийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх, идэвх санаачилгыг дэмжих

3.1.6. Төрөөс хүн амын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг орон нутгийн түвшинд хангуулах, хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцох, тайлагнах

3.1.7. Хүн амын бүлгүүдийн хөгжлийг дэмжсэн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн үр дүнг тооцох

3.1.8. Сум, байгууллагын удирдлагын хүн амын хөгжлийн асуудлаар хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнгийн тайланг хэлэлцэх, санал дүгнэлт гаргах, зөвлөмж чиглэл өгөх

3.1.9. Төрөөс хүн амын асуудлаар баримтлах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд холбогдох байгууллага, албан тушаалтад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх

3.1.10. Хорооны үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах

3.1.11. Холбогдох байгууллага, албан тушаалтаныг салбар хорооны үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр хангах

3.1.12. Сумын хэмжээнд хэрэгжүүлэх салбар зөвлөлийг байгуулан ажиллуулж, удирдлага арга зүйгээр хангах

3.1.13. Салбар хорооны үйл ажиллагааны хэрэгжилтийн тайланг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд жилд нэг удаа хэлэлцүүлж, цаашид авах арга хэмжээг төлөвлөх

ДӨРӨВ. ХОРООНЫ ДАРГА, ГИШҮҮНИЙ ҮҮРЭГ

4.1. Хорооны дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

4.1.1. Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг баталж, хугацааг товлох

4.1.2. Хуралдааны удирдах

4.1.3. Хороог төлөөлөх

4.1.4. Шаардлагатай бол тодорхой асуудлаар ажлын хэсэг байгуулж ажиллах

4.1.5. Хуралдаанаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, хорооны гишүүдийн үүрэг оролцоо, хариуцлагыг дээшлүүлэх асуудлаар чиглэл өгөх

4.2. Хорооны орлогч дарга энэхүү журмын 4.1-д заасан бүрэн эрхийг даргын эрх олгосноор хэрэгжүүлж болно.

4.3. Хорооны гишүүд дараах үүрэгтэй

4.3.1. Хүн амын асуудлаар төлөөлж буй салбарын хүрээнд авах шаардлагатай арга хэмжээний санал боловсруулан хорооны хурлаар хэлэлцүүлэх

4.3.2. Хорооны шийдвэрийг төлөөлж буй салбартаа хэрэгжүүлж, эргэн мэдээлэх

4.3.3. Хорооны хуралдаан бүрэн сууж, санал дүгнэлтээ гаргах, асуудалд бүтээлчээр хандах

4.3.4. Хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах идэвхтэй оролцох

ТАВ. ХОРООНЫ ХУРАЛДААН

5.1. Хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Хуралдааныг дарга удирдах ба түүний эзгүйд дэд дарга удирдана.

5.2. Хорооны гишүүд хурлаар хэлэлцүүлэх асуудлын талаарх саналаа хорооны нарийн бичгийн даргад ирүүлнэ.

5.3. Хорооны хуралдаанд гишүүдийн олонх оролцсоноор хүчинтэй байх бөгөөд шийдвэрийг олонхийн саналаар гаргана.

5.4. Хүндэтгэх шалтгаанаар хуралд оролцож чадаагүй гишүүдийн саналыг бичгээр тооцож болох бөгөөд хүндэтгэх бус шалтгаанаар хуралд оролцоогүй эсхүл хэлэлцэж буй асуудлыг хүлээн зөвшөөрөхгүй учраас хуралд оролцохоос татгалзсан гишүүдийг эсрэг санал өгснөөр тооцон хурлын шийдвэрийг гаргана.

5.5. Хуралдаанаас гаргах шийдвэр нь тэмдэглэл байх бөгөөд хууль, тогтоомжид нийцсэн заавал биелэгдэх шинжтэй байна.

5.6. Хурлын явцын дэлгэрэнгүй тэмдэглэл хөтлөн албажуулах үүргийг нарийн бичгийн дарга хариуцна. Хурлын тэмдэглэлийн шийдвэрт дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

5.7. Хуралдаанаас гарсан тэмдэглэлийг үндэслэн холбогдох төрийн байгууллага, албан тушаалтан хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэр гаргаж хэрэгжилтийг хангана.

5.8. Хороо нь жил бүрийн ажлын төлөвлөгөө, төсвийг боловсруулан батлуулан, хэрэгжилтийг зохион байгуулах

5.9. Нарийн бичгийн дарга хурлаар хэлэлцэх асуудлыг төлөвлөгөө, танилцуулга, шийдвэрийн төслийг боловсруулан хурал болох өдрөөс ажлын 3-5 хоногийн өмнө даргад танилцуулан батлуулж, ажлын 3-аас доошгүй өдрийн өмнө хорооны гишүүдэд хүргүүлэх.

5.10. Хорооны хурлаар хэлэлцэх асуудлын материалыг бэлдэх /Хэлэлцэх асуудлын танилцуулга, илтгэл, холбогдох тооцоо, судалгаа, санал, дүгнэлт, хавсралт, хурлаас гарах шийдвэрийн төсөл г. м/

_____оОо_____